



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэгдсэн нийт 10,664,055 /арван сая зургаан зуун жаран дөрвөн мянга тавин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тоёота Марк-2 маркийн 05-19 УБЗ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/ -т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг актлан сэлбэгийн зориулалтаар фондолж, ашиглалтын шаардлага хангахгүй болон илүүдэлтэй сэлбэгүүдийг хоёрдогч түүхий эд, сэлбэгийн зориулалтаар 300,000 /гурван зуун мянган/ төгрөгнөөс доошгүй үнээр худалдан борлуулж зохих дансанд нь орлого болгон авахыг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.



Тушаал 2019-03-13 тушаал-1 тушаал-2019-03-13

115050000157